

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫН ТАНДАН СУДАЛГАА


1. Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас эдийн засгийн өсөлтийг татварын бодлогоор дэмжих, татварын энгийн ойлгомжтой, тэгш шударга байх зарчмыг хангах, олон улсын жишигт нийцүүлэх чиглэлээр тодорхой үе шаттай арга хэмжээг авч хэрэгжүүлсний нэг нь 2015 оны 07 дугаар сарын 01-ний өдөр баталж, 2016 оны 01 дүгээр сарын 01-нээс хэрэгжүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулга юм.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд татвар төлөгчийн оролцоотойгоор бүртгэл, хяналтын тогтолцоог сайжруулах, улмаар далд эдийн засгийг бууруулах зорилгоор төлсөн албан татварын 20 хүртэл хувийг татвар төлөгчид буцаан олгох зохицуулалтыг тусгасан билээ.

Татварын буцаан олголт, урамшууллын зохицуулалт хэрэгжиж эхэлсэн болон бусад арга хэмжээний үр дүнд байгууллага, аж ахуйн нэгжид ногдуулах татварын хэмжээ жил бүр нэмэгдэж, татвар төлөлтийн хэмжээ ч сүүлийн жилүүдэд өссөн байна. Монгол Улс 2015 оноос хойш иргэн, аж ахуйн нэгжид худалдан авсан бараа үйлчилгээний үнийн дүнгийн тодорхой хувийг буцаан олгодог болсон ба сар бүр дунджаар 700 мянган татвар төлөгч баримтаа бүртгүүлж байна.

Нэмэгдсэн өртгийн албан татварын хэмжээ, өсөлтийн хувь



Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголт, урамшууллын тухай зохицуулалт хэрэгжиж эхэлснээс хойш нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын хэмжээ Ковид-19 цар тахлын нөлөөгөөр 2020 онд буурсныг эс тооцвол тогтмол өсөж ирсэн ба жилд дунджаар 19 хувиар нэмэгдсэн байна.

Татварын алба 2021 онд 2.8 их наяд төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татварын орлого улсын төсөвт төвлөрүүлжээ. Энэ нь 2015 онтой харьцуулахад 1.8 их наяд төгрөгөөр нэмэгдсэн буюу 2.7 дахин өсөөд байна. Харин Монгол Улсын ДНБ

2021 онд 43 их наяд байсан бол 2015 оноос 1.88 дахин өссөн юм. Нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын өсөлтийн хэмжээ ДНБ-ний өсөлтөөс даруй 1.93 дахин буюу 82 хувиар илүү байгаа нь далд эдийн засгийг бууруулах зорилго зорилтдоо хүрч байгаагийн илрэл гэж үзэж болохоор байна.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд заасны дагуу албан татварын 20 хүртэлх хувийг буцаан олголтын урамшуулал хэлбэрээр 2019 онд 237.2 тэрбум 2020 онд 351.8 тэрбум, 2021 онд 294.7 тэрбум төгрөгийг тус тус иргэдэд олгосон байна.

Монгол Улсын Сангийн яамны тооцооллоор 2021 онд эдийн засгийн 33 хувь нь далд байгаа бөгөөд 2017 онд 45 хувь нь татвараа төлдөг байсан бол Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар НӨАТ-ын баримтын системийг 2017 оноос нэвтрүүлснээр өнөөдөр 67 хувьд хүрсэн гэж үзсэн байна.

Дээрх судалгаанаас үзэхэд нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын өсөлтийн хурд саарч, цаашид нэмэлт арга хэмжээ авахгүй байх тохиолдолд далд эдийн засгийг бууруулах зорилго зогсонги байдалд орох магадлалтай байна.

Ковид-19 цар тахлын нөлөөгөөр бий болсон хил дамнасан тээврийн хүндрэлтэй нөхцөл байдал болон өргөн хэрэглээний барааны үнийн өсөлт иргэдийн амжиргаанд сөргөөр нөлөөлж байгаа ба Монголбанкны статистик мэдээллээр улсын жилийн инфляцын түвшин 2022 оны 2 дугаар сарын байдлаар 14.2 хувьд хүрч, 2014 оноос хойш анх удаа 10 хувийг даваад байна.

Үндэсний статистикийн хороо, Дэлхийн банкнаас Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдалд хийсэн судалгаагаар ядуурлын түвшин 2014 онд 21.6 хувь, 2016 онд 29.6 хувь, 2018 онд 28.4 хувь, 2020 онд 27.8 хувь байжээ. Ядуурлын хэмжээний бууралт хангалтгүй байгаа ба хэрвээ ковид-19 цар тахал дэгдээгүй байсан бол 3 орчим нэгж хувиар буурахаар байсан гэж дүгнэжээ.

Мөн ядуу амьдралтай иргэдийн тоо буурахгүй байгаа ба хүн амын 51.5 хувь нь ямар нэгэн төрлийн зээлтэй, нийгэм, эдийн засагт сөрөг цочрол үүсэхэд олон тооны иргэд ядууралд гулсан орох эмзэг байдалтай байна гэжээ.

2. Асуудалд дүн шинжилгээ хийсэн байдал

2.1. Асуудлыг тодорхойлж шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоох

Дээр дурдсан нөхцөл байдалд дүн шинжилгээ хийхэд дараах асуудлууд голлон анхаарал татаж байна. Үүнд:

- Сүүлийн жилүүдэд нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын өсөлтийн хурд саарсан.
- Далд эдийн засгийн хэмжээг бууруулах арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлага хэвээр байсаар байна.
- Өндөр инфляци, өргөн хэрэглээний барааны үнийн өсөлт иргэдийн амьжиргаанд сөргөөр нөлөөлж байна.

2.2. Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлох

Дээр тодорхойлсон цар хүрээтэй холбоотойгоор дараах нийгмийн бүлэг, бусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж байна гэж үзлээ.

Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг	Нөлөөлж буй хэлбэр
Иргэд	Өндөр инфляци, өргөн хэрэглээний барааны үнийн өсөлт иргэдийн амьжиргаанд сөргөөр нөлөөлж байна.
Бараа, ажил, үйлчилгээ эрхлэгчид	Далд эдийн засаг байсаар байгаа нь бизнесийн шударга бус өрсөлдөөн дотоодын зах зээлд байсаар байгааг илтгэж байна.

2.3. Тухайн асуудал үүссэн шалтгаан, нөхцөлийг тодорхойлох

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаар иргэдийн зүгээс байгууллага, аж ахуйн нэгжид тавих хяналт сайжирч, татварын орлогын суурь өргөжсөн боловч татвар төвлөрүүлэлтийн өсөлтийн хурд саарч эхлээд байна.

НӨАТ-ын буцаан олголтын өнөөгийн тогтолцоо нь далд эдийн засгийг хумих зорилгодоо хараахан бүрэн хүрч чадахгүй байгаа ба иргэдийн зүгээс тавих хяналт нь зарим төрлийн бараа, ажил, үйлчилгээнд хангалтгүй хэвээр байсаар байна.

Түүнчлэн нэмэгдсэн өртгийн албан татварын буцаалтын өнөөгийн хэмжээ нь бараа, ажил үйлчилгээнд ялгамжгүй байхаас гадна улс орны хөгжлийн бодлоготой бүрэн уялдаагүй буюу төвлөрлийг сааруулах зорилготой бүрэн нийцээгүй байна.

Цаашилбал Монголбанкны статистик мэдээллээр улсын жилийн инфляцын түвшин 2022 оны 2 дугаар сарын байдлаар 14,2 хувьд хүрч 2014 оноос хойш анх удаа 10 хувийг даваад байгаа ба өргөн хэрэглээний бараа, ажил, үйлчилгээний үнийн өсөлт иргэдийн амьжиргаанд сөргөөр нөлөөлж байна.

3. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг тодорхойлсон байдал

Хуулийн төслийг боловсруулах зорилго нь нэмэгдсэн өртгийн албан татварын буцаалтын хэмжээг тодорхой төрлийн өргөн хэрэглээний бараа, ажил, үйлчилгээнд нэмэгдүүлж, үнийн өсөлттэй холбоотойгоор иргэдэд ирж буй дарамтыг бууруулах, далд эдийн засгийг хумих, иргэдийн зүгээс тавих хяналтыг нэмэгдүүлэхэд оршино.

4. Асуудлыг зохицуулах хувилбарууд, тэдгээрийн эерэг, сөрөг талыг харьцуулсан байдал

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу нэмэгдсэн өртгийн албан татварын буцаалтын хэмжээг тодорхой төрлийн өргөн хэрэглээний бараа, ажил, үйлчилгээнд нэмэгдүүлж, үнийн өсөлттэй холбоотойгоор иргэдэд ирж буй дарамтыг бууруулах, далд эдийн засгийг хумих, иргэдийн зүгээс тавих хяналтыг нэмэгдүүлж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа.

	Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1	Тэг хувилбар	Өнөөгийн тулгамдаад байгаа шийдвэрлэх асуудал, бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй	Нэмэлт зардал гарахгүй ч, нөхцөл байдал сайжрахгүй.	Үр дүнгүй.
2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжилнэ.	Зардал тодорхой хэмжээнд гарна. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад бодитой үр дүнд хүрч чадахгүй.	Бодитой үр дүнд хүрэхгүй.
3	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл, асуудлыг шийдвэрлэх бөгөөд зорилгод хүрэх боломжтой.	Зардал гарах боловч энэ хувилбар нь асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлэх боломжтой.	Үр дүнтэй

5. Зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судалсан байдал

Сонгосон хувилбарын зорилгод хүрэх байдал, зардал, үр өгөөжийн харьцааны эерэг, сөрөг талыг харьцуулан судалбал:

Хууль, тогтоомж боловсруулах аргачлалын 6-д заасны дагуу өмнөх үе шатанд сонгон авсан хуулийн төсөл боловсруулах хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа. *Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг хүснэгт 1, 2, 3, 4-өөс үзнэ үү.*

4.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Хүний эрх, эрх чөлөөнд сөрөг нөлөө үзүүлэхгүй.

4.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Далд эдийн засгийг хумьж, бизнесийн шударга өрсөлдөөний орчин сайжирна.

4.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаалтын хэмжээг нэмэгдүүлснээр өргөн хэрэглээний барааны үнийн өсөлттэй холбоотойгоор иргэдэд ирж буй дарамтыг 2 хувиар бууруулах боломжтой.

4.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй.

4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

Сонгосон хувилбар нь Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, бусад хуультай бүрэн нийцэж байгаа болно.

6. Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулсан дүгнэлт

Аргачлалын 7-д зааснаар хувилбарын эерэг болон сөрөг талуудыг

- Зорилгод хүрэх байдал;
- Зардал, үр өгөөжийн харьцаа;
- Хүний эрх, эдийн засагт, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө;
- Хууль тогтоомжтой нийцэж буй эсэх;
- Гарч болох сөрөг үр дагавар, түүнийг арилгах хувилбар байгаа эсэх гэсэн шалгуураар дахин нягтлан үзэж дараах дүгнэлтийг хийлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн зарчим, Олон улсын хэм хэмжээний жишиг зэргийг харьцуулан дүгнэхэд дурдсан асуудлуудыг хууль боловсруулах замаар шийдвэрлэх боломжтой юм.

7. Олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа

Нэмэгдсэн өртгийн албан татвар нь эдийн засгийг удирдах “залуур” хэмээх үзэл 1980-аад онд ихээхэн түгээмэл байсан ба хувь хэмжээ, хамрах хүрээг өөрчлөх замаар дотоодын зах зээл дэх эрэлт хэрэгцээг тэнцвэржүүлэх, хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлох боломжтой гэж үздэг.

Бүгд найрамдах Солонгос улс Сангийн сайддаа НӨАТ-ын хувь хэмжээ аливаа хуулийн өөрчлөлтгүйгээр 3 хувиар өгсөж бууруулах эрх олгож байсан бол АНУ-н хувьд худалдааны татвараар энэхүү арга хэмжээг хэрэгжүүлж, муж улсууд түүнийг өөрчлөх замаар эдийн засгийн хөшүүрэг, бодлогын арга хэрэгсэл болгон ашигладаг байна.

Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаалтыг иргэдэд олгох, сугалаа зохион байгуулах туршлага харьцангуй бага боловч энэ туршлагыг БНСУ-д амжилттай хэрэгжүүлсэн байдаг.

БНСУ нь 2011-ээс 2016 оны хооронд сар бүр сугалаа зохион байгуулах, иргэдэд НӨАТ-ын буцаан олголтыг хэрэгжүүлж ирсэн. Сугалаа, буцаан олголтыг хэрэгжүүлсэн гол зорилго нь далд эдийн засгийг хумих байсан бөгөөд бүртгэлтэй татвар төлөгчдийнхөө 95 хувийг системд хамруулж, үндсэн зорилгодоо хүрсэн гэж үзсэн тул 2016 онд зогсоосон байна.

8. Зөвлөмж

Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан буцаан олголтын хувийг нэмэх замаар өргөн хэрэглээний барааны үнийн өсөлттэй холбоотойгоор иргэдэд ирж буй үнийн дарамтыг 2-4 хувиар бууруулах, нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийн тооны өсөлтийг нэмэгдүүлэх, улмаар далд эдийн засгийн хэмжээг бууруулах, төсвийн орлогын тогтвортой өсөлтийг хангах боломжтой байна.

Улмаар иргэдийн зүгээс байгууллага, аж ахуйн нэгжид тавих хяналт сайжирч, татварын орлогын бааз суурь өргөжих ба нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт сайжирч, улсад төвлөрөх татварын хэмжээ нэмэгдэх боломжтой байгаа анхаарч үзэх нь зүйтэй.

Цаашилбал далд эдийн засгийг бууруулах арга хэмжээ идэвхэжсэнээр бизнесийн шударга өрсөлдөөний орчин сайжирч иргэд, аж ахуйн нэгжийн бизнес хийх сонирхол нэмэгдэх ба татварын тэгш, шударга байх зарчим хангагдаж олон улсын жишигт нийцсэн, тогтвортой татварын орчинг бий болгоно гэж үзэж байна.

---oOo---

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт	Тайлбар
1. Хүний	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх		

эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.2. Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхүүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3. Эрх агуулагч	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Тодорхойлсон
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	дээрдүүлэхэд чиглэсэн эсэх			
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Инновацийн үйл ажиллагаанд оролцогч талуудын үүргийг тодорхойлсон
4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	Шаардлагагүй
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	шаардлагагүй

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх нөлөө:	Үр	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
			Тийм	Үгүй	
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар		1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал		2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал		3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Санхүүжилт олох боломж нэмэгдэнэ.

	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ

9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Шинээр орон тоо, нэмэлт төсөв шаардлагагүй.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	Шаардлагагүй
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Татварын дэмжлэг хөнгөлөлттэй холбоотой зарим нэг үүрэг нэмэгдэнэ
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн байдлаар зөрчилдөхгүй.

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх нөлөө:	Үр	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх		Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхтгол бий болгох эсэх		Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх		Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх		Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх		Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх		Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх		Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх		Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Холбогдох яам, агентлагуудын эрх үүргийг тодорхой болгоно
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	нөлөөлөх эсэх			
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх нөлөө:	ҮР	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Агаар		1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч		2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй